



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

**Багахангай дүүргийн “Жендэрийн эрх тэгш
байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийг
үнэлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VI хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Багахангай дүүргийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомж, дүүргийн дэд хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтийг 95,6 хувь буюу “Үр дүнтэй” гэж үнэлсүгэй.

2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Зөвлөл, Хурлын Нийгмийн бодлогын хороонд тус тус даалгасугай.

ДАРГА

Ф.МӨНХГЭРЭЛ